# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН 18, 28 ДУГААР ТОЙРОГТ ЯВАГДАХ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ НӨХӨН СОНГУУЛЬ – 2021

## АГУУЛГА


1. Нэр дэвшигчийн бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт 5

2. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахим системд үүсгэх, мэдүүлэх, баталгаажуулах тухай 17

3. Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах загвар жишээ 22


Амжилттай
уншигдлаа

# НЭР ДЭВШИГЧИЙН БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

## НАМ, ЭВСЛЭЭС НЭР ДЭВШИГЧИЙН БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

Нам, эвслээс нэр дэвшигчдийн баримт бичгийг нэр дэвшигч тус бүрээр дор дурдсан дарааллын дагуу бүрдүүлэн 2021 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

1. ***Нэр дэвшүүлсэн тухай нам, эвслийн төлөөллийн төв байгууллагын хуралдааны шийдвэр,***

2. ***Нийт нэр дэвшигчийн нэрийн жагсаалт /Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт. Маягтыг*** www.gec.gov.mn ***цахим хуудаснаас авах боломжтой./***

3. ***Нэр дэвшигч бүрийн бичгээр өгсөн зөвшөөрөл /Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт. Маягтыг*** www.gec.gov.mn ***цахим хуудаснаас авах боломжтой./***

4. ***Төрийн жинхэнэ албан хаагч, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал бол ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн шийдвэрийн хуулбар***

5. ***Банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүх болон арбитрын шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр төлбөртэй эсэх талаарх Улсын дээд шүүхийн лавлагаа.***

Лавлагаа авахдаа дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:

- Иргэний үнэмлэхийн хуулбар,
- Лавлагаа хүссэн өргөдөл, */МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон улсын Арбитрын дарга, Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 09-*

*ний өдрийн хамтарсан тушаалын хавсралт загвар 1. www.supremecourt.mn болон www.gec.gov.mn цахим хуудаснаас өргөдлийн маягтыг авах боломжтой./*

- Иргэний сүүлийн 10 жил байнга болон түр оршин суугаа газрын тодорхойлолт,
- Банк бусад хуулийн этгээд, иргэнд төлбөл зохих зээл, барьцаа батлан даалтын талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шүүх, арбитрт хариуцагчаар татагдан хэрэг хянан шийдвэрлэх оролцож байсан эсэх талаарх мэдээлэл. */МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон улсын Арбитрын дарга, Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хамтарсан тушаалын хавсралт загвар 2, 3. Мэдээллийн маягтыг www.supremecourt.mn болон www.gec.gov.mn цахим хуудаснаас өргөдлийн маягтыг авах боломжтой./*

Лавлагаатай холбоотой асуудлаар 51-261878 дугаарын утсаар мэдээлэл авах боломжтой.

## *6. Татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх, аль нэг компанийн 51 түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол тухайн компани нь татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх талаарх татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт.*

А.Нэр дэвшигч www.etax.mta.mn цахим хуудаст хандаж татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх тодорхойлолтыг авна.

Иргэн, хуулийн этгээд нь татвар төлөгчөөр бүртгүүлснээр Цахим татварын системийн хэрэглэгч болж, татварын лавлагаа, тодорхойлолт авах боломжтой болно.

Иймд иргэн www.etax.mta.mn цахим хуудаст хандан татвар төлөгчөөр бүртгүүлнэ.

*/Бүртгүүлэх зааврыг Сонгуулийн ерөнхий хорооны www.gec.gov.mn болон Татварын ерөнхий газрын www.mta.mn цахим хуудаснаас авна уу./*

Б.Нэр дэвшигч аль нэг компанийн 51 ба түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол www.etax.mta.mn цахим хуудаст хандаж байгууллагын татварын тодорхойлолтыг авна.

Тодорхойлолтыг тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан */захирал, нягтлан бодогч/* эсхүл нэр дэвшигч өөрөө цахим татварын системээс авах боломжтой.

*/Тодорхойлолт авах дэлгэрэнгүй зааврыг Сонгуулийн ерөнхий хорооны www.gec.gov.mn* болон Татварын ерөнхий газрын www.mta.mn цахим хуудаснаас авна уу./

Лавлагаатай холбоотой нэмэлт мэдээллийг 1800-1288 дугаарын утсаар авах боломжтой.

## *7. Нэр дэвшигчийн намтар*

***/Сонгуулийн Ерөнхий Хорооны 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт. Маягтыг www.gec.gov.mn цахим хуудаснаас авах боломжтой./***

### *8. Нэр дэвшигчийн иргэний үнэмлэхийн хуулбар*

### *9. Ял эдэлж байгаа эсэх талаарх Цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа.*

### *10. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа.*

Ял эдэлж байгаа эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа болон авлига албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх 2 төрлийн лавлагааг Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Статистик, мэдээллийн хэлтсийн Лавлагааны сангаас олгоно.

Лавлагааны сан нь Баянзүрх дүүргийн 2 дугаар хороо, Цагдаа хотхон, Дотоодын цэргийн 805 дугаар ангийн үүдэнд байрлах Цагдаагийн ерөнхий газрын Төв архивын байрны 1 дүгээр давхарт байрлаж байгаа бөгөөд Лавлагааны сангийн 1 дүгээр цонхоор нэр дэвшигчдэд тусгайлан үйлчилнэ. /Утасны дугаар: 70191060, 70191089./

Нэр дэвшигчийн талаарх лавлагааг тухайн нэр дэвшигчийн иргэний үнэмлэх болон түүнтэй адилтгах баримт бичиг, эсхүл тухайн нэр дэвшигч өөрийн биеэр очих боломжгүй тохиолдолд бусдад олгосон итгэмжлэлийг үндэслэн олгоно. Итгэмжлэгдсэн иргэн нь өөрийн иргэний үнэмлэх түүнтэй адилтгах баримт бичгийг авч очих ба архиваас үзүүлэх төлбөрт үйлчилгээний хураамж болох 500 төгрөгийг Төрийн сангийн 100900012027 тоот ЦЕГ-ын дансанд тушаасан баримт */арилжааны аль ч банкинд тушааж болно/*-ыг авч очно.

Ял эдэлж байгаа эсэх лавлагааг “Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт”-ын маягтаар, авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх лавлагааг албан бичгээр тус тус олгоно.

Нам, эвслээс ирүүлсэн албан бичгийн дагуу лавлагаа олгож болох бөгөөд албан бичигт төлөөлөн авах хүний талаарх мэдээллийг тусгах ба тухайн нам, эвслээс сонгуульд нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт /ургийн овог, эцэг /эх/-ийн болон өөрийн нь нэр, регистр, холбогдох утасны дугаар/-ыг үнэн зөв, гүйцэд, гаргацтай бичиж, хүний тоогоор архиваас үзүүлэх төлбөрт үйлчилгээний хураамж болох 500 төгрөгийг **Төрийн сангийн 100900012027** тоот ЦЕГ-ын дансанд тушаасан баримтыг хавсарган хүргүүлнэ.

### *11. Нэр дэвшигчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг АТГ-ын цахим системд мэдүүлсэн Баталгааны хуудас.*

*СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО*

# БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

Бие даан нэр дэвшигч нь дор дурдсан баримт бичгийг дараах дарааллын дагуу бүрдүүлэн 2021 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

***1. Нэр дэвшүүлснээ илэрхийлсэн мэдэгдэл /Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт. Маягтыг www.gec.gov.mn цахим хуудаснаас авах боломжтой./***

***2. Сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсэг зуруулсан маягт /Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан маягтыг 2021 оны 8 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн нэр дэвших гэж буй сонгуулийн тойргийн буюу Хэнтий аймгийн эсхүл Сонгинохайрхан дүүргийн сонгуулийн хороо тэмдэг дарж олгоно./***

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиас:
31.2.Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.

***(Сонгинохайрхан дүүргийн 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 21, 23, 25, 27, 28, 29, 30, 31, 38, 39, 40, 42, 43 дугаар хороо)***

31.4.Сонгогчдын гарын үсэг цуглуулах маягтад сонгогчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, хөдөлгөөнт, эсхүл суурин утасны дугаарыг тодорхой бичсэн байна.

***3. Төрийн жинхэнэ албан хаагч, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал бол ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн шийдвэрийн хуулбар***

***4. Банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүх болон арбитрын шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр төлбөртэй эсэх талаар Улсын дээд шүүхийн лавлагаа***

Лавлагаа авахдаа дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:

- Иргэний үнэмлэхийн хуулбар,
- Лавлагаа хүссэн өргөдөл, */МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон улсын Арбитрын дарга, Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын*

*09-ний өдрийн хамтарсан тушаалын хавсралт загвар 1. www.supremecourt.mn болон www.gec.gov.mn цахим хуудаснаас өргөдлийн маягтыг авах боломжтой/.*

- Иргэний сүүлийн 10 жил байнга болон түр оршин суугаа газрын тодорхойлолт,

- Банк бусад хуулийн этгээд, иргэнд төлбөл зохих зээл, барьцаа батлан даалтын талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шүүх, арбитрт хариуцагчаар татагдан хэрэг хянан шийдвэрлэх оролцож байсан эсэх талаарх мэдээлэл. */МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон улсын Арбитрын дарга, Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хамтарсан тушаалын хавсралт загвар 2, 3. Мэдээллийн маягтыг www.supremecourt.mn болон www.gec.gov.mn цахим хуудаснаас өргөдлийн маягтыг авах боломжтой./*

Лавлагаатай холбоотой асуудлаар 51-261878 дугаарын утсаар мэдээлэл авах боломжтой.

## 5. *Татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх, аль нэг компанийн 51 түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол тухайн компани нь татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх талаарх татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт.*

А. Нэр дэвшигч *www.etax.mta.mn* цахим хуудаст хандаж татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх тодорхойлолтыг авна.

Иргэн, хуулийн этгээд нь татвар төлөгчөөр бүртгүүлснээр Цахим татварын системийн хэрэглэгч болж, татварын лавлагаа, тодорхойлолт авах боломжтой болно.

Иймд иргэн *www.etax.mta.mn* цахим хуудаст хандан татвар төлөгчөөр бүртгүүлнэ.

*/Бүртгүүлэх зааврыг Сонгуулийн ерөнхий хорооны www.gec.gov.mn болон Татварын ерөнхий газрын www.mta.mn цахим хуудаснаас авна уу./*

Б. Нэр дэвшигч аль нэг компанийн 51 түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол *www.etax.mta.mn* цахим хуудаст хандаж байгууллагын татварын тодорхойлолтыг авна.
Тодорхойлолтыг тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан */захирал, нягтлан бодогч/* эсхүл нэр дэвшигч өөрөө цахим татварын системээс авах боломжтой.

*/Тодорхойлолт авах дэлгэрэнгүй зааврыг Сонгуулийн ерөнхий хорооны www.gec.gov.mn болон Татварын ерөнхий газрын www.mta.mn цахим хуудаснаас авна уу./*

Лавлагаатай холбоотой нэмэлт мэдээллийг 1800-1288 дугаарын утсаар авах боломжтой.

## 6. *Нэр дэвшигчийн намтар*
***/Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт. Маягтыг www.gec.gov.mn цахим хуудаснаас авах боломжтой/***

## 7. *Нэр дэвшигчийн иргэний үнэмлэхийн хуулбар*

***8. Бие даан нэр дэвшигчийг төлөөлж Сонгуулийн ерөнхий хороотой харилцах хоёр хүний эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, харилцах утасны дугаар***

***9. Үндэсний аудитын газраар хянуулсан сонгуулийн мөрийн хөтөлбөр***

***10. Мөрийн хөтөлбөрт хийсэн аудитын дүгнэлт***

***11. Ял эдэлж байгаа эсэх талаарх Цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа.***

***12. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа.***

Ял эдэлж байгаа эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа болон авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх 2 төрлийн лавлагааг Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Статистик, мэдээллийн хэлтсийн Лавлагааны сангаас олгоно.

Лавлагааны сан нь Баянзүрх дүүргийн 2 дугаар хороо, Цагдаа хотхон, Дотоодын цэргийн 805 дугаар ангийн үүдэнд байрлах Цагдаагийн ерөнхий газрын Төв архивын байрны 1 дүгээр давхарт байрлаж байгаа бөгөөд Лавлагааны сангийн 1 дүгээр цонхоор нэр дэвшигчдэд тусгайлан үйлчилнэ. /Утасны дугаар: 70191060, 70191089/

Нэр дэвшигчийн талаарх лавлагааг тухайн нэр дэвшигчийн иргэний үнэмлэх болон түүнтэй адилтгах баримт бичиг, эсхүл тухайн нэр дэвшигч өөрийн биеэр очих боломжгүй тохиолдолд бусдад олгосон итгэмжлэлийг үндэслэн олгоно. Итгэмжлэгдсэн иргэн нь өөрийн иргэний үнэмлэх түүнтэй адилтгах баримт бичгийг авч очих ба архиваас үзүүлэх төлбөрт үйлчилгээний хураамж болох 500 төгрөгийг **Төрийн сангийн 100900012027** тоот ЦЕГ-ын дансанд тушаасан баримт /арилжааны аль ч банкинд тушааж болно./-ыг авч очно.

Ял эдэлж байгаа эсэх лавлагааг “Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт”-ын маягтаар, авлига албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх лавлагааг албан бичгээр тус тус олгоно.

***13. Нэр дэвшигчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг АТГ-ын цахим системд мэдүүлсэн Баталгааны хуудас.***

*СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.07.07 № 01/1730

танай ______________-ны № ______________-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН 18, 28 ДУГААР ТОЙРГУУДАД ЯВАГДАХ НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ НАМ, ЭВСЭЛ БОЛОН БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧДЭД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивын тайлан ирүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын тогтоолоор Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойргуудад Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгууль явуулахаар зарласан байна.

Төрийн аудитын дээд байгууллага нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8-д "*Ээлжит бус, нөхөн сонгуулиар нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь төрийн аудитын дээд байгууллагаас тогтоосон хугацаанд сонгуулийн мөрийн хөтөлбөр болон энэ хуулийн 26.3.6, 26.4.6-д заасан хандивын тайландаа дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ*" гэж заасны дагуу дүгнэлт гаргах аудитын бэлтгэлийг ханган ажиллаж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойргуудад явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивын тайлангаа хавсралтад заасан баримт материалын хамт дор заасан хугацаанд ирүүлнэ үү. Үүнд:

- Нам, эвсэл 2021 оны 07 дугаар сарын 26,27,28-ны өдрүүдэд ажлын цагт;
- Бие даан нэр дэвшигч 2021 оны 08 дугаар сарын 23,24,25-ны өдрүүдэд ажлын цагт;

Сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивын тайлан, баримт материалыг нотлох баримтын шаардлага хангасан байдлаар битүүмжилж Үндэсний аудитын газарт ирүүлэх, шаардлагатай тохиолдолд 51-261729, 976-99085851 дугаарын утсаар холбоо барьж хамтран ажиллахыг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichiq Khereq\Yawsan Bichiq\2021\0707auditin 2-R Gazar1.Docx

001053122

Үндэсний аудитын газрын 2021 оны 07 дугаар сарын
07-ний өдрийн 01/1730 дугаар албан бичгийн хавсралт

Үндэсний аудитын газарт ирүүлэх баримт материалын жагсаалт

**Нам, эвслээс** сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивын тайлангийн хамт ирүүлэх баримт материал:

Сонгуулийн мөрийн хөтөлбөр

1. Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн эх хувийг 4 хувь хэвлэмэл байдлаар, мөн CD-нд буулгаж дугтуйлан битүүмжлэх /нам ,эвслийн нэр бичих/
2. Нэгээс гуравдугаар хавсралт маягтаар бэлтгэсэн мэдээлэл

2020 оны УИХ-ын ээлжит сонгуулиар Төрийн аудитын дээд байгууллагаар Сонгуулийн мөрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулсан нам, эвсэл хувьд сонгуулийн мөрийн хөтөлбөртөө өөрчлөлт оруулаагүй тохиолдолд дүгнэлт гаргуулсан сонгуулийн мөрийн хөтөлбөрийн баталгаажсан эх хувиа албан хүсэлт тайлбарын хамт ирүүлж болно.

Хандивын тайлан

1. Намын улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн хуулбар
2. Хавсралт 4,5-ын дагуу бэлтгэсэн хандивын тайлан /файлаар ирүүлэх/
3. 2020 оны санхүүгийн жилийн эцсийн аудитлагдсан тайлан.
4. Намын болон эвсэлд нэгдсэн орсон намуудын 2020 оны 01 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон харилцагч банкны баталгаажуулсан дансны хуулга, банкны тодорхойлолт. /данс бүрээр/

Нөхөн сонгуулийн хувьд хандивын тайлангийн хамрах хугацаа ээлжит сонгуулиас холбогдох хуулиар өөр байгааг анхаарна уу.

Хандивын тайланг файлаар tsegmiddorjd@audit.gov.mn цахим хаягаар хүлээн авна.

**Бие даан нэр дэвшигч**

1. Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн эх хувийг 4 хувь хэвлэмэл байдлаар, мөн CD-нд буулгаж дугтуйлан битүүмжлэх. /нэр бичих/
2. Зургаагаас наймдугаар хавсралт маягтаар бэлтгэсэн мэдээллийг тус тус ирүүлнэ.

Бие даан нэр дэвшигчийн хувьд хандивын тайлан ирүүлэхгүй болно.

Үндэсний аудитын газрын 2021 оны ....07 дугаар сарын ....07-ний өдрийн ..... 01/1730 дугаар албан бичгийн **зургаадугаар** хавсралт

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8-д заасны дагуу дүгнэлт гаргахтай холбогдуулан УИХ-ын гишүүний нөхөн сонгуульд оролцох **бие даан нэр дэвшигчээс** сонгуулийн мөрийн хөтөлбөрийн талаар Үндэсний аудитын газарт ирүүлэх мэдээлэл

| № | Бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ | "Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ын холбогдох зүйл, заалт | Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүүжилт шаардагдах, зардал гаргахаар тусгасан эсэх | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| | | | тийм* | үгүй | |
| | 1 | 2 | 3 | 4 | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

Жич:

- 2 дугаар баганад "Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ын ямар заалтыг үндэслэл болгосныг тодорхой бичнэ.
- 3 дугаар баганад тийм* гэх тохиолдолд зардлын мөнгөн дүнг /тэрбум төгрөгөөр / бичих.

______________________________

/нэр дэвшигчийн овог, нэр/ гарын үсэг

2021 оны ... сарын ... өдөр

Үндэсний аудитын газрын 2021 оны 07 дугаар сарын 07-ний өдрийн ..... дугаар албан бичгийн **долоодугаар** хавсралт
01/1730

**Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8-д заасан дүгнэлт гаргахтай холбогдуулан УИХ-ын нөхөн сонгуульд оролцох бие даан нэр дэвшигчээс сонгуулийн мөрийн хөтөлбөрийн талаар Үндэсний аудитын газарт ирүүлэх мэдээлэл**

| № | Бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээ | Шаардагдах зардлын нийт *(тэрбум төгрөгөөр)* | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасны дагуу шаардагдах санхүүгийн эх үүсвэр болон зардлын дүн /он тус бүрээр/тэрбум.төгрөгөөр/ | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2021 | | | | | | 2022 | | | | | | 2023 | | | | | | 2024 | | | | | | |
| | | | Улсын болон орон нутгийн төсөв 20.2.1. | Гадаадын зээл 20.2.2. | Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт 20.2.3. | Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас 20.2.4. | Концессын гэрээ 120.2.5 | Бусад эх үүсвэр, тусламж 20.2.6. | Улсын болон орон нутгийн төсөв 20.2.1. | Гадаадын зээл 20.2.2. | Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт 20.2.3. | Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас 20.2.4. | Концессын гэрээ 20.2.5 | Бусад эх үүсвэр, тусламж 20.2.6. | Улсын болон орон нутгийн төсөв 20.2.1. | Гадаадын зээл 20.2.2. | Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт 20.2.3. | Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас 20.2.4. | Концессын гэрээ 20.2.5 | Бусад эх үүсвэр, тусламж 20.2.6. | Улсын болон орон нутгийн төсөв 20.2.1. | Гадаадын зээл 20.2.2. | Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт 20.2.3. | Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас 20.2.4. | Концессын гэрээ 20.2.5 | Бусад эх үүсвэр, тусламж 20.2.6. | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 |
| 1 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 2 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |

/нэр дэвшигчийн овог, нэр/ гарын үсэг

2021 оны ... сарын ... өдөр

Үндэсний аудитын газрын 2021 оны 07 дугаар сарын 07-ний өдрийн 01/1730 дугаар албан бичгийн **наймдугаар** хавсралт

**Бие даан нэр дэвшигчийн сонгуулийн хөтөлбөрт тусгасан санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгээс хамааруулан төсвийн төсөөллийн тооцоолол хийсэн бол задаргааг гаргаж ирүүлэх маягт**

| д/д | Эдийн засгийн үндсэн үзүүлэлт | Төсвийн хүрээний мэдэгдэл | 2021-2022 оны төсвийн төсөөллийн өөрчлөх дүн | | Тооцоолсон төсвийн төсөөлөл | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024 |
| 1 | Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/ | | | | | |
| 2 | Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин | | | | | |
| 3 | Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/ | | | | | |
| | Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | | | | | |
| 4 | Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/ | | | | | |
| | Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | | | | | |
| 5 | Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/ | | | | | |
| | Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | | | | | |
| 6 | Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/ | | | | | |
| | Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | | | | | |
| 7 | Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/ | | | | | |
| | Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | | | | | |
| 8 | Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/ | | | | | |
| | Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | | | | | |
| 9 | Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/ | | | | | |
| | Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | | | | | |



# НЭР ДЭВШИГЧДИЙН АНХААРАЛД

- Нам, эвслээс нэр дэвшигч нь 2021 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн дотор ХОМ цахимаар мэдүүлэхийн тулд Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Авлигатай тэмцэх газрын даргын 2020 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн А08/А31 дугаар хамтарсан захирамж/тушаалын хавсралтаар батлагдсан “АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН МЭДҮҮЛГИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН СИСТЕМ /https://meduuleg.iaac.mn/-Д БҮРТГҮҮЛЭХ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИЙН ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН БҮРТГЭЛ, ЛАВЛАГААНЫ МАЯГТ”-ыг бүрэн гүйцэд бөглөж 9 дүгээр сарын 2-ны өдрийн дотор d.bat-erdene@gec.gov.mn цахим хаягт илгээсэн байх шаардлагатай. Уг мэдээллийг хүргүүлснээр таны и-мэйл хаягт /https://meduuleg.iaac.mn/-цахим хуудаст нэвтрэх нууц үг илгээгдэнэ.

  Бие даан нэр дэвшигчийн тухайд дэмжигч сонгогчийн гарын үсэг зуруулах маягтыг Хэнтий аймгийн эсхүл Сонгинохайрхан дүүргийн сонгуулийн хорооноос авахдаа дээрх маягтын дагуу холбогдох мэдээллийг тухайн сонгуулийн хороонд бөглөж өгнө.

  И-мэйл хаягт нэвтрэх нууц үг очих тул та өөрийн байнга ашигладаг и-мэйл хаягаа бүрэн, зөв бичих шаардлагатайг анхаарна уу.

- Нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлэгт 2020 оны 01 дүгээр сарын 01-нээс 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар өөрийн болон гэр бүлийн гишүүдийн орлого, эзэмшил, өмчлөлийн хөрөнгийг мэдүүлнэ.
- Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлогыг үнэн зөв мэдүүлэх ба мэдүүлгийн “Тайлбар” хэсэгт тухайн орлого, хөрөнгийн эх үүсвэрийг дэлгэрэнгүй бичнэ.
- 2021 оны 9 дүгээр сарын 02-ны өдрөөс 2021 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийг дуусталх 3 хоногийн хугацаанд Хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахимаар мэдүүлж, системд баталгаажуулна.
- Хөрөнгө, орлогын мэдүүлгийг мэдүүлэх хуулийн хугацаа 2021 оны

  9 дүгээр сарын 04-ний өдөр дуусгавар болох тул Авлигатай тэмцэх газрын https://meduuleg.iaac.mn/ цахим систем нь 2021 оны 9 дүгээр сарын 04-ний өдрөөс 2021 оны 9 дүгээр сарын 05-ны өдөрт шилжих шөнийн 00:00 цагт автоматаар хаагдана гэдгийг анхаарна уу.

# ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ (ХОМ)-ИЙГ https://meduuleg.iaac.mn ЦАХИМ СИСТЕМД ХЭРХЭН МЭДҮҮЛЭХ ВЭ?

## 1-Р АЛХАМ. ЦАХИМ СИСТЕМД ЭРХ ҮҮСГЭХ, НЭВТРЭХ



Сонгуулийн ерөнхий хороо болон Авлигатай тэмцэх газрын даргын баталсан маягтын дагуу Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлэх нэр дэвшигчийн талаарх мэдээллийг үндэслэн хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХОМ)-ийг цахимаар мэдүүлэх эрхийг системд тусгайлан үүсгэх тул өөрийн ашиглаж буй цахим шуудангийн хаяг, холбоо барих утасны дугаар болон бусад шаардлагатай мэдээллийг хуулийн хугацаанд багтаан Сонгуулийн ерөнхий хороонд үнэн зөв гаргаж өгсөн байх шаардлагатай. Таны өгсөн цахим шуудангийн хаягаар системд нэвтрэх нууц үгийг илгээнэ.



# 2-Р АЛХАМ. ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ МЭДҮҮЛЭХ




Хөрөнгө, орлогын мэдүүлгийн "Гэр бүлийн байдал", "Орлого", "Орон сууц" зэрэг хэсгийг бөглөхдөө загвар жишээнээс харж, дэлгэрэнгүй мэдүүлнэ.

Та өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлогыг мэдүүлэхдээ орон сууц, газар, тээврийн хэрэгслийн гэрчилгээний дугаар, хадгаламж, эзэмшиж буй дансны хуулга зэрэг шаардлагатай мэдээлэл, баримт бичгүүдийг урьдчилан бэлтгэж, бэлэн болгосон байхыг анхаарна уу.

# 3-Р АЛХАМ. ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ БАТАЛГААЖУУЛАХ




Та ХОМ-ийг баталгаажуулахдаа жагсаалтын “Дэлгэрэнгүй” гэсэн товчийг сонгож, “Дэлгэрэнгүй хуудас” хэсгээс товчийг дарна.






“ХОМ харах” товчийг дармагц ”Баталгаажуулах” товч гарч ирэх бөгөөд уг товчийг дарж, мэдүүлгээ баталгаажуулна. Мэдүүлгээ баталгаажуулмагц “Таны ХОМ амжилттай баталгаажлаа” гэсэн мэдэгдэл харагдана.






Үүний дараа "Баталгааны маягт" товчийг сонгоход системээс уг маягтыг PDF хэлбэрээр харуулах ба түүнийг хэвлэж, гарын үсэг зурж баталгаажуулан Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.






**БАТАЛГААНЫ МАЯГТ**

/Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай/

Дугаар:........ ..........он .......... сар .......... өдөр
/Баталгааны маягтыг хүлээлгэн өгсөн огноо/

/тойргийн дугаар/ Нэр дэвшигчийн /эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр

(https://meduuleg.iaac.mn/ системд бүртгэгдсэн цахим шуудангийн хаяг) /Регистрийн дугаар/

ХОМ мэдүүлсэн тайлант он:........ 2020* .............
ХОМ мэдүүлэх эрхийг цахимд үүсгэсэн огноо: ..................................................
ХОМ-ийг цахим системд баталгаажуулсан огноо: ..................................................

.............................. /эцэг/эх/-ийн нэр .............................. /өөрийн нэр/ миний бие Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.6 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсэгт заасны дагуу Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газрын (https://meduuleg.iaac.mn/) цахим системд бүрэн гүйцэд, үнэн зөв мэдүүлснээ баталж байна. Хөрөнгө, орлогыг мэдүүлэхтэй холбоотой үүргээ зөрчвөл хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

**Баталгаа гаргасан,**
Нэр дэвшигч:

/Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр /Гарын үсэг/

..........он .......... сар .......... өдөр
/Баталгааны маягтыг хэвлэсэн огноо/

# СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИЙН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ГАРГАХ ЗАГВАР ЖИШЭЭ

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны
2012 оны 05 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт

## СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИЙН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ

**Нэг. Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал:**

| **1.1. Мэдүүлэг гаргагч** | | |
|---|---|---|
| Ургийн овог: | Эцэг/эхийн нэр: | Нэр: |
| Регистрийн дугаар: | Иргэний үнэмлэхийн дугаар: | |
| Оршин суугаа газрын хаяг: **БГД, 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны 251 тоот** | Гар утас: 9999-9999<br>Ажлын утас: 7011-2469<br>Гэрийн утас: 7011-2452 | Цахим шуудангийн хаяг: |
| Боловсрол, мэргэжил: бакалавр, эрхзүйч | Байгууллагын нэр: УИХ-ын ... дугаар тойрог | |
| Төрсөн газар: Архангай, Эрдэнэбулган сум | | |
| Үндсэн харьяа: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг | Албан тушаал: Нэр дэвшигч | |

**1.2. Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал**

| Гэр бүлийн байдал | Эцэг /эх/-ийн нэр, нэр | Регистрийн дугаар | Төрсөн газар, үндсэн харьяа | Эрхэлж байгаа ажил, албан тушаал | Ажиллаж байгаа байгуулага, сурч байгаа сургууль, оршин суугаа газрын хаяг |
|---|---|---|---|---|---|
| Эхнэр, нөхөр, хамтран амьдрагч | Очирбатын Энхцэцэг | | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1 дүгээр төрөх, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг | "Улам-Ундрах" ХХК-ийн ерөнхий захирал | Ажлын хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэ, 1 дүгээр хороо, Маргад центр 545 тоот. Гэрийн хаяг: Баянгол дүүргийн 5-р хороо, 10 дугаар хороолол, 9Абайрны 251 тоот |
| Хүүхэд | Болдбаярын Тэмүүлэн | | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Эх нялхасын Эрдэм шинжилгээний төв | ОХУ-ын Нисэхийн дээд сургуульд оюутан | БГД, 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны 251 тоот |
| | Болдбаярын Хүслэн | | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Эх нялхасын Эрдэм шинжилгээний төв | Баянгол дүүргийн 13 дугаар дунд сургуульд сурагч | БГД, 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны 251 тоот |
| Эцэг | -- | -- | -- | -- | -- |
| Эх | -- | -- | -- | -- | -- |

***Тайлбар**: Хамт амьдарч байгаа болон өрхийн бүртгэлд бүртгэлтэй эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд, эцэг, эхийг бичнэ.*

**Хоёр. Хөрөнгө, орлого:**

**2.1. Орлого** /төгрөгөөр/

| № | Орлогын төрөл | Орлогын дүн | | Орлогын эх үүсвэр |
|---|---|---|---|---|
| | | өөрийн | гэр бүлийн гишүүдийн | |
| 1 | Үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | 19 024 856 | 15 650 273 | Тухайн жилд авсан өөрийн болон эхнэрийн нийт цалин хөлс |
| 2 | Шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого /албан байгууллага болон бусад хуулийн этгээд, хувь хүнээс олгосон шагнал, урамшуулал/ | 720 850 | - | Үр дүнгийн гэрээний урамшуулал болон "Төрийн албаны тэргүүний ажилтан" цол тэмдгээр шагнуулсан шагналын орлого |
| 3 | Үйл ажиллагааны орлого /үндсэн ажлаас гадуур ажиллаж олсон орлого, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсний орлого/ | 8 250 000 | - | Төмс болон чацаргана тариалж, борлуулсны орлого |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | Хөрөнгийн орлого /түрээс, эрхийн шимтгэл, ногдол ашиг, хүүгийн орлого, хөрөнгө бусдад ашиглуулсны орлого/ | - | 2 234 561 | Эхнэрийн хугацаатай хадгаламж дахь хүүгийн орлого |
| | | - | 7 200 000 | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 5-р хороо, “Өнөр” хотхоны 10-р байр, 65 тоот, 34 мкв талбайтай 1 өрөө байрыг иргэн Б.Бадамтай түрээсийн гэрээ байгуулж, хөлслүүлсэн түрээсийн орлого |
| | | 5000 000 | 15 000 000 | “Улам-Ундрах” ХХК-ийн 2020 оны ногдол ашиг |
| 5 | Хөрөнгө борлуулсны орлого /Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, хувьцаа борлуулсны орлого/ | 300 000 | - | 2020.08.09-нд “ВВВ” ХК-ийн 500ш хувьцааг “УЛС” ХК-д худалдан борлуулсны орлого |
| | | - | 35 265 000 | Япон улсаас оруулж ирсэн Ниссан Тийда автомашиныг 2020.02.25-нд иргэн Л.Доржид 11,2 сая төгрөгөөр, 2020.05.03-нд иргэн Б.Сүхбатад 13,6 сая төгрөгөөр Тоёота Гранд Марк-II автомашиныг, 2020.05.03-нд иргэн У.Ундрахад 10.5 сая төгрөгөөр Тоёота Витз маркийн (улсын дугааргүй) суудлын автомашиныг тус тус худалдан борлуулсан. |
| | | 3 600 000 | - | 2020 оны 09-р сард Архангай аймгийн Ихтамир сумын иргэн Х.Дамбад 30 толгой хонь худалдсан. |
| 6 | Хандивын орлого /бусдаас авсан мөнгөн хандив, тусламж/ | 12 000 000 | - | Эмчилгээний зардалд зориулж ах дүү, төрөл садан, найз нөхөд болон байгууллага, хамт олноос өгсөн хандив тусламжийн орлого |
| 7 | Бусад орлого /шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, бүтээгдэхүүний ашигтай загвар зохион бүтээх, спорт, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого, шагнал, төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого, төрөөс олгож байгаа бүх төрлийн мөнгөн тэтгэмжийн орлого / | - | 240 000 | 2020 онд улсаас олгосон хүүхдийн мөнгө |
| 8 | **Нийт дүн** | **48 895 706** | **75 469 798** | |

***Тайлбар**: Тайлант хугацаанд олсон өөрийн болон гэр бүлийн гишүүдийн орлогыг бичнэ.*

**2.2. Хөрөнгө, зээл**

*¤ Орон сууц, барилга, байгууламж байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх*

**2.2.1. Орон сууц, барилга, байгууламж**

| № | Орон сууц, барилга, байгууламжийн төрөл | Хийц, талбай | Байршил /хаяг/ | Зах зээлийн үнэлгээ /төгрөг/ | Бүртгэлийн гэрчилгээний дугаар | Эх үүсвэрийн тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Нийтийн орон сууц | Угсармал, 60 мкв, 3 өрөө | Баянгол дүүргийн 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны 251 тоот | 80 000 000 | Ү-2204689721 | Эцэг М.Доржоос өвлөгдсөн. Өмчлөгч Д.Болдбаяр |
| 2. | Авто гараж | Тоосгон, 12 мкв | Баянгол дүүргийн 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны дэргэд | 10 000 000 | Ү-2204689729 | 2005 онд 3 сая төгрөгөөр худалдаж авсан. Хьюндэй Соната II маркийн автомашин зарсан орлогоор авсан. |
| 3. | Зуслангийн байр | Палкан, 60 мкв, мансардтай, 2 өрөө | Сүхбаатар дүүргийн 15 дугаар хороо, Шарга морьт зуслан | 25 000 000 | Ү-2304680698 | 2007-2010 онд 15 сая төгрөгийн өртөгтэйгээр өөрсдөө барьсан. Тухайн үед банкны 10 сая төгрөгийн зээл авсан. Үлдсэн мөнгийг гэр бүлийн гишүүдийн цалин, хуримтлал, компанийн ногдол ашгийн орлогоор бий болгосон. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4. | Нийтийн орон сууц | Төмөр бетонон цутгамал, 34мкв, 1 өрөө | Баянгол дүүргийн 5 дугаар хороо, "Өнөр" хотхоны 10 дугаар байрны 65 тоот | 40 000 000 | Ү-2203512689 | 2011 онд 40 сая төгрөгөөр худалдаж авсан. Эх үүсвэр нь Орон сууц санхүүжилтийн корпорациас 35 сая төгрөг. Үлдсэн 5 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоор бий болгосон. Эхнэр, хадам эцэг, хадам ээжийн дундын өмчлөл. |
| 5. | Авто зогсоол | 15 мкв | Баянгол дүүргийн 5 дугаар хороо, "Өнөр" хотхоны 10 дугаар байрны зоорийн давхарт 15 тоот зогсоол | 14 000 000 | Ү-22016582568 | Японоос оруулж ирсэн автомашин зарсан орлогоор 2010 онд 10 сая төгрөгөөр худалдаж авсан. |
| **Нийт дүн** | | | **159 000 000** | | | |

***Тайлбар****: "Орон сууц, барилга, байгууламжийн төрөл" хэсэгт хувийн болон нийтийн орон сууц, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга, авто зогсоол, гараж, зуслангийн байр , гэр зэргийг мэдүүлнэ. "Хийц, талбай" баганад тухайн барилга байгууламжийн хийц, өрөөний тоо, талбайн хэмжээг, зах зээлийн үнэлгээг мэдүүлэг гаргах үеийн зах зээлийн ханшаар үнэлж бичнэ. Гадаад улс орон, чөлөөт бүсэд байгаа орон сууц, барилга, байгууламжийг мэдүүлнэ.*

¤ *Тээврийн хэрэгсэл байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх*

**2.2.2. Тээврийн хэрэгсэл**

| № | Тээврийн хэрэгслийн төрөл, үйлдвэрлэсэн он | Тоо, ширхэг | Гэрчилгээ, улсын дугаар, эзэмшигчийн нэр | Зах зээлийн үнэлгээ /төгрөг/ | Эх үүсвэрийн тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1. | Тоёота Клюгер, 2004 онд үйлдвэрлэгдсэн | 1 ш | АЯ123456, УНП 12-34, Д.Болдбаяр | 17 000 000 | 2010 онд 15 сая төгрөгөөр худалдаж авсан. Худалдаа хөгжлийн банкны хадгаламжаас 2 сая төгрөг, "Улам-Үндрах" ХХК-ийн ногдол ашгаас 5 сая төгрөг, урьд нь хэрэглэж байсан Гранд Марк II маркийн автомашиныг борлуулсан 8 сая төгрөгөөр эх үүсвэрийг бий болгосон. |
| 2. | Тоёота Приус, 2002 онд үйлдвэрлэгдсэн | 1 ш | АЯ654321, УБП 34-56, О.Энхцэцэг | 6 000 000 | 2009 онд 8 сая төгрөгөөр хадам эцэг, эхээс эхнэр О.Энхцэцэгт худалдаж авч өгсөн. |
| **Нийт дүн** | | | | 23 000 000 | |

***Тайлбар****: "Тээврийн хэрэгсэл" хэсэгт өөрийн болон гэр бүлийн гишүүдийн автомашин, өөрөө явагч хэрэгсэл, усан онгоц, нисэх онгоц, бусад техник, тоног төхөөрөмжийг мэдүүлнэ. Зах зээлийн үнэлгээг мэдүүлэг гаргах үеийн зах зээлийн ханшаар үнэлж бичнэ.*

¤ *Мал, аж ахуй байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх*

**2.2.3 Мал, аж ахуй**

| № | Төрөл | Тоо, толгой | Зах зээлийн үнэлгээ /төгрөг/ | Эх үүсвэрийн тайлбар | Байршил |
|---|---|---|---|---|---|
| 1. | Хонь | 126 | 11 340 000 | Өвөө Н.Мягмараас 2000 онд тасалж өгсөн 20 хонь, төлөөр өссөн. | Архангай аймгийн Ихтамир суманд нагац ах М.Рагчаагийнд байдаг. |
| 2. | Ямаа | 85 | 7 650 000 | Өвөө Н.Мягмараас 2000 онд тасалж өгсөн 20 ямаа, төлөөр өссөн. | Архангай аймгийн Ихтамир суманд нагац ах М.Рагчаагийнд байдаг. |
| 3. | Адуу | 19 | 5 700 000 | Аав М.Доржоос 2005 онд 5 адуу тасалж өгсөн, 2007 онд Хэнтий аймгаас 3 унагатай гүүг 3 сая төгрөгийн хуримтлалын орлогоор худалдаж авсан, төлөөр өссөн. | Архангай аймгийн Ихтамир суманд нагац ах М.Рагчаагийнд байдаг. |
| 4. | Хурдан удмын адуу | 5 | 5 000 000 | Найз нөхдөөс бэлэглэсэн. | Архангай аймгийн Ихтамир суманд нагац ах М.Рагчаагийнд байдаг. |
| **Нийт дүн** | | | 29 690 000 | | |

***Тайлбар:*** *"Мал, аж ахуй" хэсэгт өөрийн болон гэр бүлийн гишүүдийн таван хошуу малаас гадна туслах аж ахуйн чиглэлийн гахай, тахиа, бусад тэжээвэр амьтдыг мэдүүлнэ.*

¤ *Газар байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.*

**2.2.4 Газар**

| № | Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дугаар, он, сар, өдөр | Төрөл, хэмжээ | Байршил /бүс нутаг/, хаяг | Зах зээлийн үнэлгээ /төгрөг/ | Эх үүсвэрийн тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1. | ГД:987654, СБД-ийн Засаг даргын 2004.10.24-ний өдрийн 358 дугаартай захирамжаар | Эзэмших эрхтэй, 0,04 га | Сүхбаатар дүүргийн 15 дугаар хороо, Шарга морьт зуслан | - | Хуулийн дагуу улсаас үнэгүй авсан. |
| 2. | ГД:123456, Нийслэлийн Засаг даргын 2008.12.19-ний өдрийн 147 дугаартай захирамжаар | Эмчлэх эрхтэй, 0,07 га | Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороо, Тахилтын аманд | 4 000 000 | 2008 онд цалин, хуримтлалын орлогоор 500 000 төгрөгөөр худалдаж авсан. |
| 3. | Баянгол дүүргийн Засаг даргын 2006.10.24-ний өдрийн 322 дугаартай захирамжаар | Ашиглах эрхтэй, 108 мкв | Баянгол дүүргийн 5 дугаар хороо, 10-р хороолол, 9А байрны дэргэд | - | Гэрээгээр түр ашиглаж байгаа. |
| **Нийт дүн** | | | | **4 000 000** | |

¤ *Үнэт эдлэл, урлагийн бүтээл байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.*

**2.2.5 Үнэт эдлэл, урлаг, түүхийн үнэт зүйл**

| № | Хөрөнгийн нэр | Үнэлгээ /төгрөг/ | Эзэмшигчийн нэр | Эх үүсвэрийн болон бусад тайлбар |
|---|---|---|---|---|
| 1. | Шүрэн толгойтой халтар манан хөөрөг | 20 000 000 | Д.Болдбаяр | Өвөө Н.Мягмараас 2003 онд өвлөж авсан, өөрийн эзэмшилд хэрэглэдэг. |
| 2. | Мөнгөн тоноглой хуучны эмээл хазаар | 5 000 000 | Б.Тэмүүлэн | Эцэг М.Доржоос хүү Б.Тэмүүлэнд өвлөгдсөн. |
| | **Нийт дүн** | 25 000 000 | | |

***Тайлбар**: Энэ хэсэгт өөрийн болон гэр бүлийн гишүүдийн эзэмшиж, өмчилж, ашиглаж байгаа үнэт эдлэл, урлаг, түүхийн үнэт зүйлийг мэдүүлнэ.*

¤ Хадгаламж байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

**2.2.6 Хадгаламж, бэлэн мөнгө, хувийн харилцах болон төлбөрийн данс, картны үлдэгдэл**

| № | Банк, санхүүгийн байгууллагын нэр | Дүн /төгрөг/ | Эзэмшигчийн нэр | Эх үүсвэрийн тайлбар |
|---|---|---|---|---|
| 1. | Худалдаа хөгжлийн банкны хугацаатай хадгаламж | 26 657 500 | О.Энхцэцэг | 2005 онд 3 сая төгрөгөөр хугацаагүй хадгаламжийн данс нээлгэсэн. Цалин хуримтлалын орлого, хөрөнгө борлуулсны орлого, “Улам-Ундрах” ХХК-ийн ногдол ашгийг хадгалуулсан мөнгө. Дансны дугаар: 4080462018 |
| 2. | Худалдаа хөгжлийн банкны цалингийн карт | 237 000 | Д.Болдбаяр | Цалингийн орлого. Дансны дугаар: 4512748912 |
| 3. | Хаан банк, хувийн харилцах данс | 2 345 000 | О.Энхцэцэг | Үйл ажиллагааны орлого, өдөр тутмын гүйлгээ хийгддэг. Дансны дугаар: 5074135496 |
| 4. | Бэлэн мөнгө | 680 000 | О.Энхцэцэг, Д.Болдбаяр | Цалин, үйл ажиллагааны орлогын 2020.12.31-ний өдрийн үлдэгдэл дүн. |
| | **Нийт дүн** | 29 899 500 | | |

***Тайлбар**: Энэ хэсэгт өөрийн болон гэр бүлийн гишүүдийн гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагад байгаа бүх төрлийн данс, картны үлдэгдлийг мэдүүлнэ.*

¤ Авлага байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

**2.2.7 Авлага**

| № | Хувь хүн, хуулийн этгээдийн нэр | Дүн /төгрөг/ | Хугацаа, хүү | Тайлбар |
|---|---|---|---|---|
| -- | Д.Дагвадорж | 3 000 000 | -- | Найздаа түр зээлдүүлсэн. |
| | **Нийт дүн** | | | |

***Тайлбар**: Энэ хэсэгт өөрийн болон гэр бүлийн гишүүдийн авлагын талаар мэдүүлнэ.*

¤ Зээл байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

| **2.2.8 Зээл** | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **№** | **Зээлдүүлэгчийн нэр, хаяг** | **Анх авсан зээлийн хэмжээ /төгрөг/** | **Тухайн жилд зээл, зээлийн хүүд төлсөн дүн /төгрөг/** | **Зээл авсан, болон төлж дуусах он, сар, өдөр** | **Зориулалт** | **Зээлийн барьцаа, батлан даагч** |
| 1. | Орон сууц санхүүжилтийн корпораци | 35 000 000 | 4 236 890 | 2011.07.20-2021.07.20 | Орон сууц худалдан авах | Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 5 дугаар хороо, “Өнөр” хотхоны 10 дугаар байрны 65 тоот |
| | **Нийт дүн** | 35 000 000 | | | | |

***Тайлбар**: Энэ хэсэгт өөрийн болон гэр бүлийн гишүүдийн авсан зээлийн талаарх мэдээллийг мэдүүлнэ.*

¤ Хөрөнгө оруулалт байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

| **2.2.9 Компани, нөхөрлөл, хоршоонд оруулсан хөрөнгө оруулалт** | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **№** | **Хуулийн этгээдийн нэр, хэлбэр** | **Хувьцааны тоо** | **Нэгж хувьцааны үнэ /төгрөг/** | **Хувьцааг худалдаж авсан үнэ /төгрөг/** | **Хуулийн этгээдийн нийт дүрмийн сан /төгрөг/** | **Ногдол хувь** | **Эх үүсвэрийн тайлбар** |
| 1. | “Улам-Ундрах” ХХК | 1000 ш | - | - | 1 000 000 | 100% | 2006 онд эхнэрийн хамт үүсгэн байгуулсан. О.Энхцэцэг 75 хувийг, Д.Болдбаяр 25 хувийг тус тус эзэмшдэг. Гадаад, дотоод худалдаа, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг. |
| 2. | “Их дэлгүүр”ХК | 148 ш | 568 | - | - | - | 1991 онд цэнхэр тасалбараар улсаас үнэгүй өгсөн, өөрийн нэр дээр бүртгэлтэй. |
| | **Нийт дүн** | | | | 1 000 000 | | |

***Тайлбар**: Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн үүсгэн байгуулсан болон хувь нийлүүлсэн хуулийн этгээд, түүний толгой, охи харааt болон салбар компани, аж ахуйн нэгж, гадаад, дотоодын хөрөнгийн биржээс худалдан авсан хувьцаа, бонд, бусад үнэ цаасыг мэдүүлнэ. Хөрөнгийн эх үүсвэрийг тодорхой бичнэ.*

¤ Эрх, патент, тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

| **2.2.10 Эрх, патент, тусгай зөвшөөрөл** | | | | |
|---|---|---|---|---|
| **№** | **Төрөл** | **Эзэмшигчийн нэр** | **Тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага, огноо** | **Тайлбар** |
| 1. | Зохиогчийн эрх | Д.Болдбаяр | Оюуны өмчийн газар, 2010 он | “Ухаарлын хишиг” ном бичиж, зохиогчийн эрх авсан. |

***Тайлбар**: Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн өмчлөл, эзэмшилд байгаа зохиогчийн эрх, патент, тусгай зөвшөөрлийг мэдүүлнэ.*

| **2.5. Бэлэг, үйлчилгээ, өв залгамжлал, хандив, туслалцаа, хөнгөлөлт** | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **№** | **Эх сурвалжийн нэр, хаяг** | **Бэлэг, үйлчилгээ, өв залгамжлалын төрөл** | **Хандив, туслалцаа, хөнгөлөлтийн зориулалт** | **Үнэлгээ /төгрөг/** | **Тайлбар** |
| 1. | Хандив, туслалцаа | - | Хандив, туслалцаа | 12 000 000 | Эмчилгээний зардалд зориулж ах дүү, төрөл садан, найз нөхөд болон байгууллага, хамт олноос өгсөн хандив тусламжийн орлого |
| | **Нийт дүн** | | | 12 000 000 | |

***Тайлбар**: Тухайн албан тушаалтны нэг сарын цалингаас дээш хэмжээний бэлэг, үйлчилгээ авсныг бичнэ. Хууль ёсны өв залгамжлалаар хүлээн авсан буюу авах хөрөнгийн талаар мэдүүлнэ.*

Мэдүүлгийг үнэн зөв мэдүүлсэн: ................................................ /**Д.Болдбаяр**/

/гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/

… оны … дугаар сарын …-ны өдөр